



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/626

Хэрлэн сум

Инженерийн хийцтэй худаг хүлээн авах  
ажлын комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 05-ны 101/189/194 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн завсарлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт төсөл болон орон нутгийн төсөв хөрөнгөөр хөдөөгийн хүн ам мал аж ахуй. бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 6 сумын нутагт 2022 онд шинээр гаргасан 6 инженерийн хийцтэй худгийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Нарийн бичгийн дарга	Гүйцэтгэгч компанийн төлөөлөл
Гишүүд:	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн Аймгийн Төслийн ажилтан Сумдын Засаг дарга Сумдын Хөдөө, аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2.Шинээр гаргасан инженерийн хийцтэй худгийг MMS 6088:2010 стандарт, техникийн тодорхойлолт, зөвлөмжид заасан баримт, материалын дагуу хүлээн авч, дүгнэлтээ танилцуулахыг Комиссын даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ